# СОЁЛЫН ӨВИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
# 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 1.1. | **Зорилт 1**. Салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | | | | | | |
| 1.1.1 | Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, АХ 2050-1.1.4, МУХТЖҮЧ-1.1.4, ЗГҮАХХАХТ-2.6.3.6, МУХТҮЧ-1.13.218 | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн эсэх | Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа хийгдсэн. | 100% | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцын орчуулгыг албан ёсоор Гадаад харилцааны яаманд хүргүүлэн хянуулж байна. Конвенцын орчуулга нь Хууль зүй, дотоод хэргийн яам болон анх орчуулсан эхтэй ойлголтын зөрүү гараад байгаа тул нэгтгэх уулзалт хийх шаардлагатай болсоноос ажил бага зэрэг хойшилогдоод байна. Конвенцын танилцуулга, үзэл баримтлал, хууль боловсруулахтай холбоотой урьдчилсан бэлтгэл, холбогдох материалыг бэлтгэсэн. | IV улирал | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.2 | Нүүдлийн соёл, иргэншлийн судлах олон улсын хүрээлэнгийн дүрэмд өөрчлөлт оруулах шийдвэрийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн эсэх | Дүрэмд өөрчлөлт оруулах төслийг 2023 оны 11 дүгээр сард оролцогч талуудад танилцуулж, зөвшилцсөн. | 100% | Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотноо 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр гарын үсэг зурсан "Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэнг үүсгэн байгуулах тухай 1998 оны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, холбогдох материалыг бэлтгэн 19 яамнаас санал авч нэгтгэн 18 төрлийн 60 хуудас материалыг бэлтгэн Засгийн газарт хүргүүлэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар оруулан дэмжигдсэн. | III улирал | 100% |
| 1.1.3 | Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, **ХТТХ 51.2, СӨХТХ 9 дүгээр зүйл** | Үнэлгээ хийгдсэн эсэх | Хууль 56, Дүрэм, журам 29<br>Стандарт 2 | 100% | Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардагдах зардлыг Сайдын 2024 оны А/117 тоот тушаалаар батлуулав. Тушаалын дагуу Олон улсын гэрээ хэлэлцээр, үндэсний хууль тогтоомж хоорондын үзэл санааны нийцлийн судалгааг Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгээр, Соёлын өвийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг "Оюуны инноваци" ТББ, Олон улсад соёлын өвийг хамгаалах эрх зүйн орчны туршлага гэсэн чиглэлийн судалгааг "Соёлын олон илэрхийллийн олон төрлийг хамгаалах зөвлөл" ТББ-аар тус тус гэрээ байгуулан гүйцэтгүүлж тайланг хүлээн авсан. | III улирал | 100% |

89

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.4 | Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх багц хуулийн төслийг боловсруулах, **АХ 2050-1.1.4,** | Хуулийн үзэл баримтлал батлагдсан эсэх | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан | 100% | Соёлын өвийг тодорхойлох, бүртгэх, судлах, хадгалах, сэргээх, засварлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахаар "Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх", Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаар "Түүхэн барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах тухай", Төрөөс соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, соёлын биет бус өвийг хамгаалах оролцоо, эрх үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг дэмжих тухай", Соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтнох чадварт нөлөөллийн үнэлгээ хийх эрх зүйн үндсийг бүрдүүлж, үнэлгээний ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, хяналт тавих, баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлж "Соёлын өвд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн төслийг тус тус боловсруулсан. | III-IV улирал | 40% |
| 1.1.5 | Гандантэгчэнлин хийд орчмын орон зайг Үндэсний соёлын өвийн дурсгалт газар болгох шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн эсэх | Засгийн газрын 2024 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 6 дугаар | 100% | Соёлын сайдын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/90 дүгээр тушаалаар Монголын Бурханы Шашинтны төв-Гандантэгчэнлин хийд орчмын газар нутгийг Үндэсний соёлын өвийн дурсгалт газрын ангиллаар хамгаалалтад авах асуудлыг судалж, | III-IV улирал | 40% |

96

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлэлцүүлэх **АХ 2050-1.1.4, 1.1.12, 8.2.3** | | тэмдэглэл гарсан. | | танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийг Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга ахлаж байгаа бөгөөд Соёлын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас бүрдсэн 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр холбогдох судалгааны ажлыг хэрэгжүүлсэн бөгөөд Гандантэгчэнлин хийд орчмын газар нутгийг Үндэсний соёлын өвийн дурсгалт газрын ангиллаар хамгаалалтад авснаар Монгол Улсын үндсэн хууль холбогдох бусад хууль тогтоомж, Дэлхийн өвийн конвенцтой хэрхэн уялдах, мөн дурсгалт газрын одоогийн нөхцөл байдалд үзүүлэх нөлөөлөл, үр дагавар, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг олон талын асуудлыг нарийвчлан судлах ажлыг ойрын хугацаанд дуусган, шийдлийн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгээд байна. | | |
| **ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 2.1 | **Зорилт 1.** Соёлоор дамжуулан соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлж, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 2.1.1 | Дэлхийн өвийн үндэсний урьдчилсан жагсаалтыг шинэчлэх | Шинэчилсэн жагсаалтын төслийг | 2014 онд баталсан Дэлхийн | 100% | Чингис хаан үндэсний музей нь ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй байгуулсан гэрээний дагуу "Хүннүгийн | III-IV улирал | 100% |

91

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээг зохион байгуулах, **72 оны конвенцын үйл ажиллагааны удирдамжийн 62-69 дэх заалт** | бэлтгэсэн эсэх | өвийн үндэсний урьдчилсан жагсаалт | | язгууртны оршуулгын цогцолбор" соёлын өвийн 5 (1. Төв аймгийн Борнуур, Батсүмбэр сум, Сэлэнгэ аймгийн Мандал сумын заагт орших "Ноён уул", 2. Архангай аймгийн Хайрхан сумын нутагт орших "Гол мод-1", 3. Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт орших "Гол мод-2", 4. Хэнтий аймгийн Баян-Адрага сумын нутагт орших "Дуурлиг нарс", 5. Ховд аймгийн Манхан сумын нутагт орших "Тахилгын хотгор") дурсгалт газрыг ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд нэр дэвшүүлэхээр номинацийн баримт бичгийг боловсруулан, 2024 оны 9 дүгээр сарын 01/420 дугаар албан бичгээр ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссоор дамжуулан Дэлхийн өвийн хороонд хүргүүлсэн. ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй байгуулсан СОЯ 24/132 гэрээний дагуу 2024 оны 9 дүгээр сарын 14-15-ны өдөр Архангай аймгийн Тариат сумын Мөрөн багийн нутагт "Суман голын хадны зураг" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан. тус хуралд Архангай аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга, мэргэжилтнүүд, Цэнхэр, Өндөр-Улаан сумын Соёлын төвийн дарга, музейн төлөөллүүд, Архангайн ТВ, 1-р 10 жил, Тариат, Чулуут, Хотонт, Түвшрүүлэх сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн багш нар зэрэг нийт 82 том хүн, 118 сурагч болон нутгийн ард иргэд оролцсон. | | |

92

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 | Соёлын биет бус өвийг ЮНЕСКО-гийн төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай өвийн жагсаалтад бүртгүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, **АХ 2050-1.5.1, МУХТҮЧ-1.5.1, ЗГҮАХХАХТ-ний 2.6.1.7** | Бүртгүүлсэн өвийн тоо | 2023 онд "Наурыз", "Монгол нүүдлийн зан үйл" өвийг бүртгүүлэхээр нэр дэвшүүлж, баримт бичгийг конвенцын Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн. | 100% | Соёлын биет бус өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 2003 оны конвенцын Нарийн бичгийн дарга нарын газраас ирүүлсэн CLT/LHE/24/285, CLT/LHE/24/288 тоот албан бичгийн дагуу Монгол Улсаас 2022, 2023 онд Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлсэн “Наурыз”, “Монгол нүүдлийн зан үйл” өвүүдэд холбогдох нэмэлт мэдээллийг бэлтгэж, Франц Улс дахь Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн Газарт цахим шуудангаар хүргүүлсэн. Тус хүргүүлсэн материалыг Үнэлгээний Хороо хүлээн авч танилцан, 2024 оны 11 дүгээр сарын 05-ний өдөр дээрх өвүүдийг бүртгэх тухай урьдчилсан шийдвэрийг гаргасан. Бүгд Найрамдах Парагвай Улсын Асунсион хотноо 2024 оны 12 дугаар сарын 02-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Соёлын биет бус өвийг хамгаалах Засгийн газар хоорондын хорооны 19 дүгээр чуулганаар "Монгол нүүдлийн зан үйл", “Наурыз” өвийг ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэх тухай 8b49, 8b56 тоот урьдчилсан шийдвэрийг баталж, ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний Соёлын биет бус өвийн жагсаалтад албан ёсоор бүртгэсэн. | IV улирал | 100% |

93

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.3 | "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, Соёлын биет бус өртөг гаргах, **СТХ 8.5** | Соёлын өвийн өртөөг гаргасан эсэх | 2023 онд Соёлын өвийн өртөөг 12 өвийн чиглэлээр зохион байгуулсан. | 100% | Засгийн газрын 2024 оны "Фестиваль зохион байгуулах тухай" 41 дүгээр тогтоолын дагуу "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг 2024 оны 8 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Фестивальд 12 улсын 140 гаруй гадаад оролцогч, Монгол Улсын 21 аймаг, нийслэлээс 1000 орчим өвлөн уламжлагчид, салбарын 150 гаруй байгууллага оролцож, соёлын биет бус өвийн 7 ай савын 362 төрлөөр 780 хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулсан. Фестивалийг 169,000 хүн үзэж сонирхсон бөгөөд аймаг, нийслэлийн соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид болон 40 гаруй хоол үйлдвэрлэгчид оролцож, 21,000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаж, нийт 2,2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. | III улирал | 100% |
| 2.1.4 | Хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэмэлт оруулах арга хэмжээг зохион байгуулах, **СӨХТХ- 13.1.8** | Зэрэглэл тогтоосон дурсгалт зүйлийн тоо | Засгийн газрын шийдвэрээр 1995-2019 онд нийт 778 дурсгалт зүйлд хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэл тогтоосон | 100% | "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам"-ын дагуу Соёлын өвийн үндэсний төвөөс төрийн болон орон нутгийн өмчийн 9 музей, 1 иргэнээс 148 дэсийн 391 ширхэг дурсгалт зүйлийг түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлд нэр дэвшүүлэх санал ирүүлснээс 8 музей, 1 иргэний 113 дэсийн 311 ширхэг дурсгалын баримтыг бүрдүүлсэн. СӨБХЗГ баримт материалтай танилцаад 30 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг түүх, соёлын үнэт дурсгалт зүйлд нэр дэвшүүлэхэд бэлтгэн баримтын бүрдлийг хангаад байна. | III-IV улирал | 70% |

94

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.5 | Монголын ард түмний оюун санааны нэгдмэл байдлыг илэрхийлэх бэлгэ тэмдэг болсон түүхэн суут хүний алдар, дүр төрхийг эрхэмлэн, хүндэтгэлтэй хандаж, хамгаалах журмын төслийг боловсруулж батлуулах **СТХ-8.3** | Журмын төсөл боловсруулсан эсэх | Журмын төслийг боловсруулах суурь судалгаа хийсэн. | 100% | ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс Монголын ард түмний оюун санааны нэгдмэл байдлыг илэрхийлэх бэлгэ тэмдэг болсон түүхэн суут хүн хэн байж болох талаар санал авсан. Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс Чингис хаан болон анхдугаар Богд Занабазар гэсэн түүхэн 2 хүний санал өгсөн. Чингис хаан өв соёлын хүрээлэнгээс Чингис хааны дүр төрхийг эрхэмлэн, хүндэтгэлтэй хандах, хамгаалах чиглэлээр санал ирүүлсэн. Журмын төслийг 6 бүлэг, 16 зүйл бүхий байхаар боловсруулсан. | III-IV улирал | 70% |
| 2.1.6 | Нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох журмыг боловсруулж, хүргүүлэх **СӨХТХ- 9.1** | Журмын төсөл боловсруулсан эсэх | Журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу боловсруулсан. | 100% | ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс Монголын ард түмний оюун санааны нэгдмэл байдлыг илэрхийлэх бэлгэ тэмдэг болсон түүхэн суут хүн хэн байж болох талаар санал авсан. Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс Чингис хаан болон анхдугаар Богд Занабазар гэсэн түүхэн 2 хүний санал өгсөн. Чингис хаан өв соёлын хүрээлэнгээс Чингис хааны дүр төрхийг эрхэмлэн, хүндэтгэлтэй хандах, хамгаалах чиглэлээр санал ирүүлсэн. Журмын төслийг 6 бүлэг, 16 зүйл бүхий байхаар боловсруулсан.<br>Зорилт 2. Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд:<br>Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7-д түүхийн дурсгалт зүйл, үнэт эдлэл, эрдэнэс, ховор эд зүйлийн үнэлгээний журам, аргачлалыг Монголбанк болон соёлын асуудал | III-IV улирал | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална гэж заасан хууль хоорондын нэр томьёоны ойлголт зөрж байгаа тул Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газар, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын төлөөлөлтэй 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдөр уулзалт хийж ярилцан хуулинд өөрчлөлт оруулах санал боловсруулахаар ярилцсан. Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орж Соёлын биет өвийн үнэлгээний журам, аргачлалыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран батлахаар заасан. Үнэлгээний журмын төслийг боловсруулж Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газар, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын төлөөлөлд саналыг илгээсэн. | | |
| 2.1.7 | Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг боловсруулж, батлуулах **СӨХТХ-35.1** | Журмын төсөл батлагдсан эсэх | Журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу боловсруулсан. | 100% | Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 35.1-д заасны дагуу Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмын төслийг боловсруулсан. Журмын төслийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Чингис хаан Үндэсний музей дээр зохион байгуулсан “Монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалтын мэргэжилтний чадавхыг дээшлүүлэх” сургалтын үеэр музейн сан хөмрөгчдөд танилцуулан санал авч тусган, дахин зарим боловсруулалтыг хийж байна. | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.8 | Хамгаалалтын бүсийн хилийн заагийг тогтоох шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулж, батлуулах **СӨХТХ-45.1** | Шалгуур үзүүлэлтийн төсөл батлагдсан эсэх | Төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан, төслийг боловсруулсан. | 100% | Барилга, хот байгуулалтын сайд, Соёлын сайдын хамтарсан 2024 оны 30/А43 дугаар тушаалаар Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг тогтоох шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийг 2024 оны 9 дүгээр сард хуралдуулж, хамгаалалтын бүсийн хилийн заагийг тогтоох шалгуур үзүүлэлтийн төслийг эцэслэн боловсруулсан бөгөөд соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлуулахаар бэлтгэсэн. | III-IV улирал | 100% |
| 2.1.9 | Түүхэн дурсгалт, барилга архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг төслийг боловсруулж батлуулах **СӨХТХ-47.2** | Журмын төсөл батлагдсан эсэх | Соёлын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2023 оны А/413, 247 хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. | 100% | Журмын төслийг боловсруулж, нөлөөллийн шинжилгээг хийсэн бөгөөд Соёлын яамны дэргэдэх Соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн саналыг журмын төсөлд тусгасан. Соёлын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны А/413/247 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан ажлын хэсгийг хуралдуулж, журмын төслийг эцэслэн боловсруулсан бөгөөд соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлуулахаар бэлтгэсэн. | III-IV улирал | 70% |

97

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулж байгаа ажлуудын нэг юм.<br>Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотын Чехийн Үндэсний музейтэй хамтран үзэсгэлэн зохион байгуулах бэлтгэл ажлыг хангуулахаар Соёлын сайдын 2024 оны А/108 дугаар тушаалаар 7,1 сая төгрөгийг баталж Чингис хаан Үндэсний музейн захирал С.Чулууныг томилолтоор явуулж тайланг хүлээн авсан.<br>“Дэлхийд тархсан Монгол өв” төслийн хүрээнд ХБНГУ-д хадгалагдаж буй Монголын түүх, соёлын өвийн дурсгалуудаар каталоги гаргахаар зохих судалгааг хийсэн. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотын Угсаатны музей, Үндэсний номын санд буй Монголтой холбоотой дурсгалуудаар “Герман дахь Монгол өв” каталоги бэлтгэх, дурсгалуудын зураг авч хэвлэлийн эхийг бэлтгэн хэвлэж түгээхэд бэлэн болсон. | | |
| 3.1.2 | Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны 100 жилийн ойн хүндэтгэлийн хурал зохион байгуулах<br>**Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам 1.2** | Аяныг зохион байгуулсан эсэх | Музейн 100 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөөнд туссан. | 100% | Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны түүхэнд 100 жилийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай Соёлын сайдын 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн “Ой тэмдэглэх, ажлын хэсэг байгуулах тухай” А/478 дугаар тушаал, Соёлын дэд сайдын баталсан “Музей 100 жилийн тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө”-ний 14-т төлөвлөсний дагуу “Музейн 100 жил-Хүндэтгэлийн хурал” зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.<br>Хүндэтгэлийн хурлын арга хэмжээг | III-IV улирал | 100% |

101

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нийгмийн хариуцлагын үүднээс "Музейн нэгэн зууны түүхэн хөгжил түүхэн антологи", "Монголын музейн хөгжил - 100 жил" нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх ажлыг Соёлын сайдын 2024 оны "Зардал баталж, эрх шилжүүлэх тухай" А/271 дүгээр тушаалаар 40 сая төгрөг, ССАЖЗ-ын сайдын 2024 оны "Зардал батлах тухай" А/45 дугаар тушаалаар 35 сая төгрөгийн зардлыг тус тус шийдвэрлэж бүтээлгэсэн. "Музейн нэгэн зууны түүхэн хөгжил түүхэн антологи" бүтээх ажлыг Чингис хаан үндэсний музей эрхлэн гүйцэтгэв. Антологи нь 3 бүлэгтэй. Нэгдүгээрт бүлэг "Монгол Улсад орчин цагийн музейн салбар үүсэн бүрэлдсэн нь 1924-1955 он", Хоёрдугаар бүлэгт "1955-1990 оны музейн түүхэнд холбогдох түүхэн 89 баримт, 90 орчим гэрэл зураг, мөн гадаад орнуудад толилуулагдсан олон улсын үзэсгэлэн, хэвлэл бүтээл зэрэг баримтууд багтсан", Гуравдугаарт бүлэгт "1992 оноос 2024 оны үед холбогдох музейн түүхэн баримтууд болон өдгөө Монгол Улсад үйл ажиллагаа"-ны гэрэл зураг, холбогдох тайлбарыг багтсан. "Монголын музейн хөгжил - 100 жил" нэг сэдэвт бүтээл нь 4 бүлэг, 15 зүйл, 14 дэд зүйл, өмнөх үг, дүгнэлт, ном зүй, хавсралтаас бүтсэн. Бүтээлд сан хөмрөгийн бүрдэл, хадгалалт, хамгаалалт, үзэсгэлэн зэрэг музейн 100 жилийн түүхийн өгөгдлийн сан үүсгэж, тайлбарыг оруулсан. "Монголын | | |

103

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | музейн үүсэл” хэмээх нэгдүгээр бүлэгт “Монголчуудын сонин зүйлийг хураан үзүүлж, таниулах уламжлал”, “Монгол Улсын шинжлэх ухааны байгууллагаас музейн салбарыг үүсгэн байгуулсан нь”, “Музейн сан хөмрөг бүй болгосон нь”, “Олон нийтэд зориулсан үйл ажиллагаа”, “Музейн гадаад харилцаа” гэсэн зүйлийг; “Музейн салбарын төлөвшил” хэмээх хоёрдугаар бүлэгт “Музейн удирдлага, зохион байгуулалт”, “Музейн үйл ажиллагаа”, гадаад, дотоод хамтын ажиллагаа гэсэн зүйлийг; “Нийгмийн өөрчлөлтийн үеийн музей” хэмээх гуравдугаар бүлэгт “Музейн талаарх бодлогын үзэл баримтлалын өөрчлөлт”, “Музейн үйл ажиллагааны зохион байгуулалт”, “Хүний нөөцийн бодлого, хэрэгжилт”, “Гадаад харилцаа” гэсэн сэдэвт зүйлийг; “Музейн судалгаа хөгжүүлэлт” хэмээх дөрөвдүгээр бүлэгт “Музейн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт”-ын хүрээнд эрдэм шинжилгээний ажил эрхлэх нэгж, хүний нөөц, музейн арга зүйн судалгаа – сургалтын асуудал, “Салбар дундын судалгааны үр дүн музейд нэвтэрснийг түүх, угсаатны зүй, археологи, байгалийн ухааны судалгаа” гэсэн хүрээнд, музейн судалгааны үр дүнг музей судлалын хөгжил, ном бүтээл, шинжлэх ухааны төсөл, хөтөлбөрийн тоон үзүүлэлт, үр дүн талаас нэгтгэн дүгнэж бичиж оруулсан. | | |

104

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4 | Музейн салбарын нэгдсэн чуулган зохион байгуулах. **Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам 1.2** | Аяныг зохион байгуулсан эсэх | Музейн 100 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөөнд туссан. | 100% | "Музей 100 жилийн тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө"-ний 14-т тусгасаны дагуу Соёлын сайдын 2024 оны "Зардал баталж, эрх шилжүүлэх тухай" А/271 дүгээр тушаалаар 30 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Тус арга хэмжээний зохион байгуулалтыг Чингис хаан Үндэсний музей хангаж ажилласан. "Монголын музей-100" нэгдсэн чуулганг 2024 оны 09 дүгээр сарын 5-ны өдрөөс 7-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Хархорин суманд зохион байгуулсан. ССАЖЗ-ын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн "Дотоод томилолтын удирдамж"-аар тус яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн, Түүх, соёлын дурсгалт зүйл, музейн бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Ш.Энхтуяа, мэргэжилтэн Ц.Цолмон нар оролцож илтгэж тавьж, хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр ажилласан. Чуулганд төрийн болон орон нутгийн өмчийн музей, сумын орон нутаг судлах музей, байгууллагын болон хувийн музей, аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар зэрэг 31 байгууллагын нийт 388 төлөөлөл оролцсон.<br>Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн чуулганг нээж Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номингийн мэндчилгээг дэвшүүлж, | III-IV улирал | 100% |

105

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Музейн талаарх төрийн бодлого, зорилт” илтгэл тавьлаа. Чуулганд оролцсон бүх музей өөрийн байгууллагын түүхэн замнал, онцлог үйл ажиллагаа, цаашдын хөгжлийн чиг хандлагаа тодорхойлсон ППТ танилцуулага бэлтгэж оролцсон нь бие биеэсээ суралцсан онцлог үр дүнтэй ажил боллоо. Чуулганы үеэр СӨАЖЗ-ын Сайдын 2024 оны А/12 дугаар тушаалаар орон нутгийн өмчийн 25 музейд “Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” гардуулж, музейн салбарт үр бүтээлтэй ажилласан 19 албан хаагчдад төрийн болон салбарын одон медаль гардуулсан. Чуулган зохион байгуулалт сайтай, ажил хэрэгч болж өндөрлөв. | | |
| 3.1.5 | Үндэсний соёлын өвийг ЮНЕСКО-гийн төрөлжсөн жагсаалтад нэр дэвшүүлэх, бүртгүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх **АХ 2050-1.5.1, МУХТҮЧ -1.5.1** | Бүртгэсэн өвийн тоо, Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтын төслийг боловсруул сан эсэх | 15 соёлын биет бус өв, 6 баримтат өвийг бүртгүүлсэн. | 100% | ЮНЕСКО-ийн "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн Олон улсад баримтат өвийн жагсаалтад 2025 онд шалгаруулж бүртгүүлэхээр “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” баримтат өвийг ШУА-ийн Монголын Анагаах ухааны академиар, "Хүйс толгойн бичээс" баримтат өвийг Монгол Улсын Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаар тус тус судалгааг хийлгэж маягтын дагуу бэлтгэж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн.<br>Соёлын сайдын 2023 оны А/458 дугаар “Зардал батлах тухай” тушаалаар тус ажилд дэмжлэг үзүүлсэн, 2023 онд 2/3204 “Баримтат өвийн тухай” албан бичгийн ЮНЕСКО-ийн МУК-ын Ерөнхий | IV улирал | 100% |

106

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нарийн бичгийн даргад ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Олон улсын НБДГ-т хүргүүлэх хүсэлт хүргүүлсэн. | | |
| 3.1.6 | **Иргэдийн гар дээр болон хувийн аж ахуйн нэгж, сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэх**<br><br>**АХ 2050-1.1.4, МУХТҮЧ-1.1.4, ЗГҮАХХАХТ-2.6.3.6** | Шинээр бүртгэсэн баримтат өвийн тоо | 2023 онд 3200 баримтат өвийг бүртгэсэн. | 100% | 2024 оны эхний хагас жилд 742, сүүлийн хагас жилд 2396 нийт 3138 баримтат өвийг "Монгол Улсын баримтат өвийн бүртгэл мэдээллийн нэгдсэн жагсаалтад баримтат өвийг бүртгэх" маягтын дагуу бүртгэсэн. 2021-2024 онд "Монгол Улсын баримтат өвийн бүртгэл мэдээллийн нэгдсэн жагсаалт"-ад баримтат өвд холбогдох 17 төрөл зүйлийн нийт 18686 дурсгал бүртгэгдсэн. | III-IV улирал | 100% |
| 3.1.7 | Уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичиг болон баримтат өвийг сурвалжлан олж бүртгэх, сурталчлах ажлыг зохион байгуулах **АХ - 2050 - 1.1, УИХ-ын 2022 оны 01 тогтоол** | Сурвалжлан олж бүртгэсэн өвийн тоо | Уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичгийн үзэсгэлэн, хэвлүүлсэн ном, соёлын өвийн үндэсний бүртгэл | 100% | ЗГХА Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, нийслэл, 21 аймгийн Соёл, аялал жуулчлал, залуучуудын газар, угийн бичиг хөтлөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Угийн бичгийн академи" ТББ, "Их Монголын ураг удмын нэгдэл" НҮТББ, "Уг удам, өв соёлын холбоо" НҮТББ, "Прогнэт" ХХК-тай хамтран ажиллаж уламжлалт аргаар хөтөлсөн 6 угийн бичгийг сурвалжлан олсон. | III-IV улирал | 100% |

107

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.8 | Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулах **АХ 2050-1.1.9, ЗГҮАХХАХТ-ний 2.6.3.7** | Зохион байгуулсан сургалтын тоо | 2024 оны 2 дугаар сард оролцогч талуудын төлөөлөл (40 хүн)-ийг оролцуулсан сургалт, уулзалтыг зохион байгуулсан. | 100% | Соёлын өвийн үндэсний төвөөс ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран “Соёлын өвийг хамгаалах, соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй төрийн албан хаагчдын хамтын ажиллагааг сайжруулах, хууль эрх зүйн мэдлэг олгох” сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 04-ний зохион байгууллаа.<br>Сургалтад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Түүх соёлын дурсгалт зүйлийн хууль бус эргэлттэй тэмцэх тасаг болон 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг болон сумдын Цагдаагийн байгууллага болон Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Улс, орон нутгийн өмчийн музей зэрэг соёлын өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагын 214 албан хаагчид хамрагдав. | III-IV улирал | 100% |
| 3.1.9 | Хилийн чанадад байгаа соёлын өвийг бүртгэх арга хэмжээг хэрэгжүүлэх **АХ 2050-1.5.3, СТХ27.1.3, ЗГҮА 27.1.4** | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | "Монгол өв ба дэлхий дахин" арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. | 100% | Хилийн чанадад буй Монгол Улсын холбогдолтой соёлын өвийн https://abroad.mongoluv.mn цахим программыг хөгжүүлэн “Дэлхийд тархсан Монгол өв” төслийн хүрээнд хэвлэгдсэн 20 цувралаас 3 боть, Бонныя их сургуулийн Дорно дахин, Ази судлалын хүрээлэнгээс хэрэгжүүлж буй Европын улс орнуудын музейнүүд | III-IV улирал | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон хувь хүний цуглуулга дахь Монгол, Төвөдийн соёлын биет өвийн үзмэрүүдийн мэдээллийг судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглаж 1200 өвийн мэдээллийг цахим бүртгэлийн программд оруулсан.<br>Үүнд:<br>-Норвеги дахь Монголын өв соёлын дурсгалууд. Мариа Картвеит 2023 (424 өвийн мэдээлэл)<br>-Монгол болон Дорно дахины бурханы шашны өв (XVII-XX зуун) А.И.Шинковой 2023. (214 өвийн мэдээлэл)<br>-Эрмитаж дахь Монголын гоёл чимэглэл, гар урлалын дурсгалууд. Ю.И.Елихина 2023 (200 өвийн мэдээлэл)<br>-Боннын их сургуулийн Дорно дахин, Ази судлалын хүрээлэнгийн http://echo-monger.imdt.ac.mn/ сайтаас (362 өвийн мэдээлэл).<br>Үр дүн: Хилийн чанадад буй Монголын соёлын өвийг эрэн сурвалжлах, судалгааны эргэлтэд оруулах замаар нэгдсэн мэдээллийн сан бий болгож төрөөс гадаадад буй Монголын соёлын өвийн талаар тогтвортой, оновчтой бодлого шийдвэр гаргахад бодит дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой. | | |

109

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.10 | Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хооронд соёлын өвийг хамгаалах тухай хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллах **АХ 2050-1.1.9, ЗГҮАХХАХТ-ний 2.6.3.7** | Хэлэлцээрийн төслийг боловсруулсан эсэх | АНУ-ын талд Монгол Улсын соёлын өвийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдлын талаарх танилцуулга, хүсэлтийг хүргүүлсэн. | 100% | АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Энтони Блинкен Монгол Улсад 2024 оны 7 дугаар сард хийсэн айлчлалын үеэр Монгол Улсын Гадаад харилцааны яамны сайд Монгол Улс Америкийн Нэгдсэн Улс хооронд соёлын өвийг хамгаалах тухай хэлэлцээр байгуулах тухай саналаа илэрхийлж, хэлэлцээр байгуулахад шаардлагатай мэдээллийг АНУ-ын талд хүргүүлсэн.<br>АНУ-аас асуудлыг судлахаар АНУ-ын Төрийн департментийн Соёл, боловсролын Соёлын өвийн төвийн Гадаад хэргийн шинжээч Анн Комптон Монгол Улсад 2024 оны 8 дугаар сард хүрэлцэн ирж ССАЖЗ-ын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Гадаад харилцааны яамны холбогдох албан тушаалтан болон Соёл, урлагийн газар, Чингис хаан Үндэсний музей зэрэг байгууллагатай танилцаж мэдээлэл авсан ба Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн, яамны холбогдох мэргэжилтэн, шинжээч нартай 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдөр, 8 дугаар сарын 29-ны өдөр тус тус уулзалт хийж зарим шаардлагатай нэмэлт мэдээллэл авч, АНУ-ын Төрийн департментын дэргэдэх Соёлын өмчийн зөвлөх хорооны хурлыг зохион байгуулахаар төлөвлөсөн.<br>АНУ-ын Төрийн департментын дэргэдэх Соёлын өмчийн зөвлөх хорооноос 2024 оны 9 дүгээр сарын 25- | III-IV улирал | 100% |

110

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны өдөр цахим уулзалт зохион байгуулсан. Уулзалтад АНУ-ын Цагаан ордноос томилогдсон Төрийн департментын дэргэдэх Соёлын өмчийн зөвлөх хороо, Археологи, Антропологийн салбар, соёлын өвийн олон улсын худалдаа болон олон нийтийг төлөөлөл оролцсон нийт 11 гишүүн, Монгол Улсын талаас Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн, яамны холбогдох мэргэжилтэн, шинжээч, Гадаад харилцааны яамны Америк, ойрхи дорнод, далайн орнуудын газрын II нарийн бичиг дарга Г.Хулан болон Гаалийн Ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын төлөөлөл 8 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Монгол Улсын соёлын өвийг хамгаалах бодлого, үйл ажиллагаа, соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэж байгаа талаар мдэлгэрэнгүй мэдээллэл өгч, нэмэлт асуултанд хариулсан. АНУ-ын тал соёлын өмчийг хамгаалах тухай хэлэлцээрийг байгуулах хүсэлтийг судлан үзэж, зөвлөмжөө АНУ-ын Төрийн департментад хүргүүлэхээ мэдэгдээд байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.11 | "Кембриж Монгол II форум: Дэлхийн асуудал, нүүдэлчдийн шийдэл" олон улсын хурлыг зохион байгуулах,<br>**АХ 2050-1.1.9,** | Хурлыг зохион байгуулсан эсэх | Камбриж Монгол II форумыг 2022 онд Лондон хотноо зохион байгуулсан. | 100% | ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.4-т тусгасан арга хэмжээний<br>хүрээнд дэлхий нийтэд тулгарч буй асуудлуудыг нүүдэлчдийн уламжлал, өв соёлын<br>өнцгөөс хэрхэн шийдвэрлэх тухай онцлох зорилготой “Кембриж Монгол Форум II”-ыг<br>2024 оны 8-р сарын 19-20-ны өдрүүдэд Монгол Улсын Их Сургууль дээр зохион байгуулав. “Дэлхийн асуудал, Нүүдэлчдийн шийдэл” хэмээх сэдвийн дор явагдсан<br>энэхүү форумд Монгол болон нүүдэлчдийн соёлыг өвлөн хадгалж буй бусад орнуудын<br>судлаачид, олон улсын монголч эрдэмтэд, соёл урлаг зэрэг нийгэм, хүмүүнлэгийн<br>салбарын төлөөллүүд өргөнөөр оролцсон. | III улирал | 100% |
| 3.1.12 | Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг орон нутгийн өмчийн музейд олгох<br>**ЗТХ- 8.1 дүгээр зүйлийн 7.5, МТХ- 5.4** | Тусгай зөвшөөрөл олгосон музейн тоо | 2023 онд Төрийн өмчийн 10 музейд олгосон. | 100% | Музейн тухай хуулийн 5.4, 5.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн 7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ССАЖЗ-ын Сайдын 2024 оны дугаар сарын 15-ны өдрийн А12 дугаар тушаалаар орон нутгийн өмчийн 24 музей, төрийн өмчийн 1 музей /Хөшөө цайдам музей/ нийт 25 байгууллагад “Музейн үйл ажиллагаа эрхлэх тухай зөвшөөрөл” олгосон. Зөвшөөрлийн гэрчилгээг 2024 оны 9 дүгээр сарын 05-ны өдөр | III улирал | 100% |

112

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Өвөрхангай аймгийн Хархорум суманд зохион байгуулагдсан "Монголын музей 100 жил" нэгдсэн чуулганы үеэр гардуулсан. | | |
| **3.1.13** | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, палеонтологи, археологийн судалгааны дээжид улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох. **ЗТХ, СӨХТХ 14.1.11** | Зөвшөөрөл олгосон тоо | 2023 оны 33 лиценз олгосон | 100% | Засгийн газрын 2018 оны 121 дүгээр тогтоолоор баталсан "Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам", Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолоор баталсан "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам", "Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт" дагуу ШУА-ын Археологийн хүрээлэн, МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, МУИС-ийн Нүүдлийн археологийн хүрээлэн, ШУТИС-ийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн хүсэлтээр нийт 2047 дээжийг АНУ, ХБНГУ, Польш, Япон, Канад, Испани, БНХАУ, Солонгос улсын их сургуулийн лабораторид шинжлүүлэхээр "эргэж ирэхгүй нөхцөлөөр" 22, "эргэж ирэх нөхцөлөөр" 3 нийт 25 дээжид "D" хавсралтаар лиценз олгосон. Нийдээ 2024 онд 40 лиценз олгогдсон нь өмнөх жилүүдээс хамгийн их олгосон байна. | III-IV улирал | 100% |
| **ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ** | | | | | | | |
| 4.1 | **Зорилт 1.** Соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | | | | | | |

113

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Google art platform дээр Монголын соёлын биет өвийг байршуулах ажлыг зохион байгуулах, | Platform дээр байршуулсан мэдээллийн тоо | 2023 онд 6 мэдээлэл байршуулсан. | 100% | ССАЖЗЯ болон харьяа байгууллагуудын Google arts & culture талбарт нэвтрэх, мэдээлэл байршуулах 22 эрхийг үүсгэн баталгаажуулж, 7 музейн мэргэжилтэнд уг талбарт оруулах мэдээлэл, контентыг бүрдүүлэх, бэлтгэх арга зүйн зөвлөгөөг 14 удаа өгч, шаардлагатай нэмэлт гэрэл зургийн баримтжуулалтын ажлыг тухайн байгууллагууд дээр хийж гүйцэтгэв.<br>“Google arts and culture” талбарт 6 байгууллагын 52 сэдэв (story), 645 мэдээлэл (item)-ийг оруулж, embed кодыг Үндэсний төвийн www.ncch.gov.mn цахим хуудсанд байршуулсан.<br>Үүнд:<br>-ССАЖЗЯ-ны талбарт 3 сэдэв, 126 мэдээлэл;<br>-Монголын үндэсний музейн талбарт 10 сэдэв, 105 мэдээлэл;<br>-Богд хааны ордон музейн талбарт 17 сэдэв, 101 мэдээлэл;<br>-Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн талбарт 11 сэдэв, 101 мэдээлэл;<br>-Монголын уран зургийн галерейн талбарт 6 сэдэв, 109 мэдээлэл;<br>-Монгол цэргийн музейн талбарт 5 сэдэв, 103 мэдээлэл;<br>-ЮНЕСКО-д бүртгэгдсэн соёлын биет бус 15 өвийн видео контент;<br>-Улс, аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх 30 дурсгалын видео контент; | III-IV улирал | 100% |

114

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрт бүртгэлтэй 7 баримтат өв;<br>-Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн Буган чулуун хөшөө болон хүрлийн үеийн холбогдох дурсгалууд;<br>-Монголын XIII-XIV зууны үеийн хүн чулуу зэрэг болно.<br>Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн Буган чулуун хөшөө болон хүрлийн үеийн холбогдох дурсгалууд, баримтат өвийн сэдвийг Үндэсний төвийн www.ncch.gov.mn цахим хуудас, Соёлын салбарын нэгдсэн портал (portal.moc.gov.mn) цахим хуудсанд embed хийж байршуулсан. | | |
| | **Нийт** | | | | | | **85.9** |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

СОЁЛЫН ӨВИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА

Б.ДАВААЦЭРЭН / .............................. /

......... ......... .........

*( Огноо )*

115

СОЁЛЫН ӨВИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА Б.ДАВААЦЭРЭНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭЖЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам**

Нэгжийн нэр: **Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар**

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| **Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ** | | | |
| **Зорилт 1. Салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | 40 | 28 |
| 2 | Арга хэмжээ 1.2. Нүүдлийн соёл, иргэншлийн судлах олон улсын хүрээлэнгийн дүрэмд өөрчлөлт оруулах шийдвэрийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | 100 | 70 |
| 3 | Арга хэмжээ 1.3. Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх | 100 | 70 |
| 4 | Арга хэмжээ 1.4. Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх багц хуулийн төслийг боловсруулах, | 40 | 28 |
| 5 | Арга хэмжээ 1.5. Гандантэгчэнлин хийд орчмын орон зайг Үндэсний соёлын өвийн дурсгалт газар болгох шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | 40 | 28 |
| **Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | |
| **Зорилт 2. Соёлоор дамжуулан соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлж, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ.** | | | |
| 1 | Арга хэмжээ 2.1. Дэлхийн өвийн үндэсний урьдчилсан жагсаалтыг шинэчлэх арга хэмжээг зохион байгуулах | 100 | 70 |
| 2 | Арга хэмжээ 2.2. Соёлын биет бус өвийг ЮНЕСКО-гийн төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай өвийн жагсаалтад бүртгүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | 100 | 70 |
| 3 | Арга хэмжээ 2.3. "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, Соёлын биет бус өртөөг гаргах | 100 | 70 |
| 4 | Арга хэмжээ 2.4. Хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэмэлт оруулах арга хэмжээг зохион байгуулах | 70 | 49 |
| 5 | Арга хэмжээ 2.5. Монголын ард түмний оюун санааны нэгдмэл байдлыг илэрхийлэх бэлгэ тэмдэг болсон түүхэн суут хүний алдар, дүр | 70 | 49 |

| | | | |
|---|---|---|---|
| | төрхийг эрхэмлэн, хүндэтгэлтэй хандаж, хамгаалах журмын төслийг боловсруулж батлуулах | | |
| 6 | Арга хэмжээ 2.6. Нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох журмыг боловсруулж, хүргүүлэх | 40 | 28 |
| 7 | Арга хэмжээ 2.7. Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг боловсруулж, батлуулах | 100 | 70 |
| 8 | Арга хэмжээ 2.8. Хамгаалалтын бүсийн хилийн заагийг тогтоох шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулж, батлуулах | 100 | 70 |
| 9 | Арга хэмжээ 2.9. Түүхэн дурсгалт, барилга архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг төслийг боловсруулж батлуулах | 70 | 49 |
| 10 | Арга хэмжээ 2.10. Угийн бичиг хөтлөх журмыг боловсруулж, батлуулах | 40 | 28 |
| 11 | Арга хэмжээ 2.11. Орон нутгийн музейн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад үнэлгээ хийх этгээдэд тавих шалгуур, үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж, батлуулах | 70 | 49 |
| 12 | Арга хэмжээ 2.12. Монгол Улсын харьяат 16 хүртэлх насны хүүхдийн хувийн музейгээр үйлчлүүлсэн холбогдох зардлыг нөхөн олгох олгох журмын төслийг боловсруулж батлуулах | 70 | 49 |
| 13 | Арга хэмжээ 2.13. Соёлын биет өвийг сэргээн засварлах журмын төслийг боловсруулж, батлуулах | 100 | 70 |
| **Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | |
| **Зорилт 3. Соёлын өвийг таньж тогтоох, илрүүлэх, хадгалах, хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, бүс нутагтаа тэргүүлэх үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.** | | | |
| 1 | Арга хэмжээ 3.1. “Монгол өв ба дэлхий дахин” дунд хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэх | 100 | 70 |
| 2 | Арга хэмжээ 3.2. Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны 100 жилийн ойн хүндэтгэлийн хурал зохион байгуулах | 100 | 70 |
| 3 | Арга хэмжээ 3.3. "Музейн нэгэн зууны түүхэн хөгжил антологи", "Монголын музейн хөгжил" нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх. | 100 | 70 |
| 4 | Арга хэмжээ 3.4. Музейн салбарын нэгдсэн чуулган зохион байгуулах. | 100 | 70 |
| 5 | Арга хэмжээ 3.5. Үндэсний соёлын өвийг ЮНЕСКО-гийн төрөлжсөн жагсаалтад нэр дэвшүүлэх, бүртгүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | 100 | 70 |
| 6 | Арга хэмжээ 3.6. Иргэдийн гар дээр болон хувийн аж ахуйн нэгж, сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэх | 100 | 70 |
| 7 | Арга хэмжээ 3.7. Уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичиг болон баримтат өвийг сурвалжлан олж бүртгэх, сурталчлах ажлыг зохион байгуулах | 100 | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | Арга хэмжээ 3.8. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулах | 100 | 70 |
| 9 | Арга хэмжээ 3.9. Хилийн чанадад байгаа соёлын өвийг бүртгэх арга хэмжээг хэрэгжүүлэх | 100 | 70 |
| 10 | Арга хэмжээ 3.10. Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хооронд соёлын өвийг хамгаалах тухай хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллах | 100 | 70 |
| 11 | Арга хэмжээ 3.11. "Кембриж Монгол II форум: Дэлхийн асуудал, нүүдэлчдийн шийдэл" олон улсын хурлыг зохион байгуулах, | 100 | 70 |
| 12 | Арга хэмжээ 3.12. Музейн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг орон нутгийн өмчийн музейд олгох | 100 | 70 |
| 13 | Арга хэмжээ 3.13. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, палеонтологи, археологийн судалгааны дээжид улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох. | 100 | 70 |
| **Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** | | | |
| 14 | Арга хэмжээ 4.1. Google art platform дээр Монголын соёлын биет өвийг байршуулах ажлыг зохион байгуулах | 100 | 70 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1 | Арга хэмжээ 1. Гураваас доошгүй гадаад орнуудын эрх зүйн орчны туршлагыг судлана. | 100 | 15 |
| 2 | Арга хэмжээ 2. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжийн талаар сургалтад хамрагдана. | 100 | 15 |
| 3 | Арга хэмжээ 3. Соёлын өвийг судлах чиглэлээр 1 бүтээл хэвлүүлнэ. | 100 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | **15** |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | |
| 2 | Удирдан зохион байгуулах | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | |

| | | |
|---|---|---|
| 4 | Манлайлах | |
| 5 | Багаар ажиллах | |
| 6 | Харилцаа | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8 | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9 | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.) (70 хүртэлх оноо)* | 56.7 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(15 хүртэлх оноо)* | 15.0 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ) *(15 хүртэлх оноо)* | 15 |
| 4 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (*Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих*) | |
| **Нийт оноо** | | 86.7/90 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
*(албан тушаал)*

.................................
*(гарын үсэг)*

(А.Даваажаргал)
*(албан хаагчийн нэр)*

2024.12.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
*(албан тушаал)*

.................................
*(гарын үсэг)*

(Б.Даваацэрэн)
*(албан хаагчийн нэр)*

2024.12.13 (огноо)

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# СОЁЛЫН ӨВИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ШИНЖЭЭЧ О.МЭНДСАЙХАНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Усан доорх соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | Хуулийн төслийг өргөн мэдүүлсэн эсэх | Хуулийн хэрэгцээ шаардлагын урьдчилсан судалгаа хийгдсэн. | 100% | Усан доорх соёлын өвийг хамгаалах конвенцын орчуулгыг албан ёсоор Гадаад харилцааны яаманд хүргүүлэн хянуулж байна. Конвенцын орчуулга нь Хууль зүй, дотоод хэргийн яам болон анх орчуулсан эхтэй ойлголтын зөрүү гараад байгаа тул нэгтгэх уулзалт хийх шаардлагатай болсоноос ажил бага зэрэг хойшилогдоод байна.<br>Конвенцын танилцуулга, үзэл баримтлал, хууль боловсруулахтай холбоотой урьдчилсан бэлтгэл, холбогдох материалыг бэлтгэсэн. | 8-12 | 70% |
| 2. | Арга хэмжээ 1.2. Соёлын өвийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр | Үнэлгээ хийгдсэн эсэх | Хууль 56, Дүрэм, журам 29 Стандарт 2 | 100% | Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардагдах зардлыг Сайдын 2024 оны А/117 тоот тушаалаар батлуулав. Тушаалын дагуу Олон улсын гэрээ хэлэлцээр, үндэсний | 9-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дагаварт үнэлгээ хийлгэх. | | | | хууль тогтоомж хоорондын үзэл санааны нийцлийн судалгааг Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгээр, Соёлын өвийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг "Оюуны инноваци" ТББ, Олон улсад соёлын өвийг хамгаалах эрх зүйн орчны туршлага гэсэн чиглэлийн судалгааг "Соёлын олон илэрхийллийн олон төрлийг хамгаалах зөвлөл" ТББ-аар тус тус гэрээ байгуулан гүйцэтгүүлж тайланг хүлээн авсан. | | |
| 3 | Арга хэмжээ 1.3. Нүүдлийн соёл, иргэншлийн судлах олон улсын хүрээлэнгийн дүрэмд өөрчлөлт оруулах шийдвэрийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн эсэх | Дүрэмд өөрчлөлт оруулах төслийг 2023 оны 11 дүгээр сард оролцогч талуудад танилцуулж, зөвшилцсөн | 100% | Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотноо 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр гарын үсэг зурсан "Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэнг үүсгэн байгуулах тухай 1998 оны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, холбогдох материалыг бэлтгэн 19 яамнаас санал авч нэгтгэн 18 төрлийн 60 хуудас материалыг бэлтгэн Засгийн газарт хүргүүлэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар оруулан дэмжигдсэн. | 9-12 | 100% |
| 4 | Арга хэмжээ 1.4. Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх багц хуулийн төслийг боловсруулах | Хуулийн үзэл баримтлалыг төслийг боловсруулсан эсэх | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан | 100% | Соёлын өвийг тодорхойлох, бүртгэх, судлах, хадгалах, сэргээх, засварлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахаар "Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх", Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаар "Түүхэн барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах тухай", Төрөөс соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг | 8-12 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, соёлын биет бус өвийг хамгаалах оролцоо, эрх үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг дэмжих тухай", Соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтнох чадварт нөлөөллийн үнэлгээ хийх эрх зүйн үндсийг бүрдүүлж, үнэлгээний ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, хяналт тавих, баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлж "Соёлын өвд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн төслийг тус тус боловсруулсан. | | |
| **ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **Зорилт 1. "Соёлын салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, цахим шилжилтийг хийнэ"** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Google art platform дээр Монголын соёлын биет өвийг байршуулах | Platform дээр байршуулсан мэдээллийн тоо | 2023 онд 6 мэдээлэл байршуулсан. | 100% | ССАЖЗЯ болон харьяа байгууллагуудын Google arts & culture талбарт нэвтрэх, мэдээлэл байршуулах 22 эрхийг үүсгэн баталгаажуулж, 7 музейн мэргэжилтэнд уг талбарт оруулах мэдээлэл, контентыг бүрдүүлэх, бэлтгэх арга зүйн зөвлөгөө 14 удаа өгч, шаардлагатай нэмэлт гэрэл зургийн баримтжуулалтын ажлыг тухайн байгууллагууд дээр хийж гүйцэтгэв. "Google arts and culture" талбарт 6 байгууллагын 52 сэдэв (story), 645 мэдээлэл (item)-ийг оруулж, embed кодыг Үндэсний төвийн www.ncch.gov.mn цахим хуудсанд байршуулсан.<br>Үүнд:<br>-ССАЖЗЯ-ны талбарт 3 сэдэв, 126 мэдээлэл;<br>-Монголын үндэсний музейн талбарт 10 сэдэв, 105 мэдээлэл;<br>-Богд хааны ордон музейн талбарт 17 сэдэв, 101 мэдээлэл; | 8-12 | 100% |

92

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
